

ТАЙЛБАР БИЧИГ

Ерөнхий хэсэг

Улаанбаатар хот , Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо УБДС ТӨХК -ийн харьяа Даралт өргөх насос №10 станцын дэргэд байрлах "Цэцэрлэгт хүрээлэн-1" 112МВт ачаалалтай хийн түлшээр ажиллах дулааны эх үүсвэрийн барилгын зураг төсөл боловсруулах даалгавар №2022/ Д - болон ТЭЗҮ -г баримтлаж " Каркас зураг " ХХК -д 2024 онд боловсруулав . Ажлын зургийн баримт бичгийг дараах барилгын ангилалын эзрэгүүдэд тооцож гүйцэтгэв .
Шифр : KZ-2022.07.03


Ажлын зургийн баримт бичгийг дараах цаг уурын нөхцөлд, барилгын ангилалын эзрэгүүдэд тооцож гүйцэтгэв. Үүнд:
Гадна агаарын хэм - 39.0 ° C
Салхины хурд - 35кг / м2
Цасны ачаалал - 50 кг / м2
Газар чичирхийлэл - 8 балл
Үүнд :
Эдэлгээний зэрэг - II
Галд тэсвэрлэлтийн зэрэг - I
Барилгын ангилал - I

Зураг төсөлд зохиоход ашигласан норм дүрмүүд :

1. БНБД 30-01-04 Хот , тосгоны төлөвлөлт, барилгажилт
2. БНБД 31-11-09 Үйлдвэрийн барилга
3. БНБД 31-16-11 Үйлдвэрийн газрын байгууламж
4. БНБД 31-19-10 Агуулахын барилга
5. БНБД 32-01-07 Автозам төсөллөх
6. БНБД 42-02-04 Хийн хангамж

Барилга архитектурын хэсэг

Д/Д	БАРИЛГЫН БҮРДЭЛ	ТАЙЛБАР
1	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал	Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо УБДС ТӨХК-ийн "Цэцэрлэгт хүрээлэн-1" хийн түлшээр ажиллах 112МВт /93,3 Гкал/ц/ ачаалалтай дулааны эх үүсвэрийн барилга.
2	Барилгын урт, өргөн давхрын хэмжээ	Уг барилга нь байгуулалтаараа 78 х 27м-ийн хэмжээтэй, +0.00, +3.90 гэсэн түвшинтэй үйлдвэрийн барилга.
3	Барилгын төрөл, хийц	Цутгамал төмөр бетон суурьтай, ган каркас хийцлэл бүхий сандвич хавтан дулаалага, хучилттай.
4	+0.00 түвшин	Зуухны өрөө, Ус бэлтгэлийн хэсэг, Дулаан хангамжийн хэсэг, Оффис өрөө, Холбоо дохиоллын өрөө, Ариун цэврийн өрөө, Душ өрөө, Амралтын өрөө, Шатны хонгилын өрөө байрлана.
5	+3.90 түвшин	Дулааны станцын удирдах ажилтан, ИТА-ийн өрөө, Удирдлагын өрөө зэрэг байрлана.
6	Гадна хана	Гадна хана 200мм Basaltwool сандвич хавтан дулаалагатай, дотор талаасаа темалайн TL /идэмхий бодисоос хамгаалах түрхлэг/ түрхлэгээр түрхэнэ. Сэндвич ханыг зурагт заасан өнгийн дагуу хийнэ.
7	Дотор хана	Дотор хана ±0.00 түвшиний давхрын оффисийн хэсэгт 120мм тоосгон өрлөгөөр, зуухны өрөө болон ус бэлтгэлийн хэсгийг 200мм-н Basaltwool хавтан ханатай ба +3,90 түвшиний давхрын оффисийг 120мм Basaltwool сандвич хавтан ханатай байхаар төлөвлөв.
8	Цонх, хаалга	Монгол Улсын стандарт MNS 62660:2011 мөн MNS 5830:2007 нормын дагуу тусгай захиалгаар метал рамтай галд тэсвэртэй целлюлоз цонх захиалж угсарна. Үйлдвэрийн ISO 9001 стандарт технологи шаардлага хангасан материал ашиглана. Цонх бүрт ган торон хаалт хийхээр төлөвлөв. Хаалга нь мөн стандартын дагуу галд тэсвэртэй, дуу тусгарлагчтай байна.
9	Шат	Метал бүтээцтэй шат байх ба маш бат бөх хийх шаардлагатай. 50мм цайрдагсан ган баруултай, 50х25 босоо тулгууртай, 20х20 хөндлөвчтэй хашлага хийнэ. Гшгүүрийн ирмэгт халтирахаас хамгаалсан ховил татах буюу зориулалтын металл оруулга суулгаж өгнө. Мөн Темалайн TL идэмхий бодисоос хамгаалах түрхлэг эсвэл "Эпоксид" түрхлэг түрхэнэ.
10	Шал: Шалны төрөл	Шалны ажлыг хийхээс өмнө сантехник, цахилгааны, тоног төхөөрөмжийн угралтын ажлыг дуусгасан байх шаардлагатай. +0.00 түвшиний шалыг В10 маркийн 200мм-ийн зузаантай бетон цутгаж, дээр нь фибер бетон шал 50мм-ийн зузаантай хийж "Эпоксид" түрхлэг түрхэнэ. +3.90 түвшиний шалыг 150мм-ийн зузаантай төмөр бетоноор цутгаж, 50мм-ийн тэгшилгээ хийж дээд доод талд нь "Эпоксид" түрхлэг түрхэнэ.
11	Дээвэр	Олон үе давхаргаас бүрдсэн MNS 4629:2007 стандарт, технологи хангасан материалтай байх. Чур ус тусгаалагч цаас хийхдээ яндан, агааржуулалтын хоолой, паргнет зэрэг босоо хийц элементийг өөд авиргаж, тойруулан наах ба цаас хоорондын зөрүүлэг 10-15см-с багагүй байх. Дээвэр нь 160-ийн С төмөр болон 250мм-ийн сандвичин дээвэр болно. Барилгын 4Өм-н уртын дагуу 2 тийшээ тэнцүү i=9.9% налуулагатай ба Y1, Y4 тэнхлэгийн дагуу борооны усыг цуглуулж 150мм-н 4 борооны ус зайлуулах босоо шугмаар барилгын 2 тал уруу нийт 8 босоо ган хоолойгоор борооны ус зайлна.
12	Дотор засал	Багана, дамнуруу, хучилт, шал, таазанд идэмхий бодисоос хамгаалах темалайн TL түрхлэг эсвэл "Эпоксид" түрхлэг түрхэнэ. Оффисийн өрөөнүүд нь 60х60см-н метал дүүжин таазтай. Ариун цэврийн өрөөний ханыг +2.40 түвшин хүртэл листадаж, тааз хүртэл ус чийгэнд тэсвэртэй эмүльсэр 2 үе будна. Ариун цэврийн өрөөний таазыг ус чийгэнд тэсвэртэй эмүльсэр 2 дахин будна.
13	Гадна засал	X1-X14 тэнхлэгт 150х150мм гоёлын төмөр төлөвлөв. X9-X1 тэнхлэгт галын төмөр шат хийнэ (БА хуудас - 21 үзнэ). Гадна довжоог барзгар гадаргуутай, халтирдаггүй чулуугаар өнгөлнө. Янданг халхалж хамгаалалтын төмөр нүхтэй хавтангаар далдалж өгнө.

	УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 26-Р ХОРОО. ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН-1 112МВт ЧАДАЛТАЙ ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН БАРИЛГА				Ye шат: A.3		
	Тайлбар бичиг						
	Архитектор	<i>Б.Хонгор</i>	Б.Хонгор	Е.Г.Шифр: KZ-2022.07.03		Масштаб: М1:	Огноо: 2024
	Гүйцэтгэсэн	<i>Б.Хонгор</i>	М.Уянга	Т.Г.Шифр:		Зургийн дугаар: БА-02	Хуудас: 27
"КАРКАС ЗУРАГ"ХХК		Шалгасан	<i>Б.Хонгор</i>	Б.Хонгор			